


Увс аймгийн Улаангом сум 12-р багийн төрийн байгууллагуудыг шилэн кабельд холбох техникийн даалгавар



2020.02.11

Дугаар: ЗТ-...../2020

Улаангом сум

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	2020 оны Төсвийн тухай хуулийн 1.1.17-р заалт, Увс аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр.
2.	Байршил:	Увс аймаг, Улаангом сум .
3.	Хөрөнгийн эх үүсвэр :	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан
4.	Захиалагч байгууллага:	МХС, Увс аймгийн Засаг даргын тамгын газар.
5.	Шилэн кабельд хийгдэх ажлууд	<p>1. МХС ТӨК -н байр, 3 байгууллага тус бүрд 19", 12U rack тус бүр суурилуулж дотор 12 шөрмөсийн FDF байрлуулж залгаа хийнэ. Rack газардуулгатай холбогдсон байна. Рак бүрд тог баригч суурилуулсан байна.</p> <p>2. МТ ШТС -н уулзар дээр зам хөндлөн гарах хэсэгт 2 бетон багана босгож кабелийг агаараар гаргах</p> <p>3. МХС ТӨК-н байрнаас сувагчлалаар 1800м, онцгой байдлын уулзвараас Нарлаг худалдааны төвийн арын гудамжаар доош 2400м 12корын газрын шилэн кабель татах</p>
6.	Угсралтын ажлын үед тавигдах шаардлага:	<p>1. Төсөл хэрэгжих сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах газар эзэмших зөвшөөрөлийг холбогдох сумын захиргаанаас захирамж гаргуулах.</p> <p>2. Кабелийн гадна төмөр бүрээсийг FDF дээр бэхлэх ба FDF ерөнхий газардуулгатай холбогдсон байна.</p> <p>3. Кабелийн муфтыг шилэн кабелийн трасстай үргэлжлүүлэн хажуу тийш 1м-н зайнд гарган авто замын чиглэл талд ухаж суурилуулах ба кабелийн нөөц нь чиглэл тус бүрт 15 м байна.</p> <p>4. Кабелийн хэмжилтийг хоёр чиглэлд хийж хэвлэж хавсаргах мөн file-р өгөх.</p> <p>5. Кабелийн тэмдэгтийн шонг стандартын дагуу хийх. Шонг 0,6м гүнд суурилуулна. Муфтын шонгийн толгой тал нь бусад шонгоос ялгаатай байна. Муфтны шон дээр МХС-J1,J2..., бусад</p>

шонгууд дээр МХС-1,2... гэх мэтээр хар будгаар дугаарлана.

6. Гүйцэтгэгч кабель татахтай холбогдох бүх зөвшөөрлүүдийг авах ба үүнтэй холбогдон гарах зардлыг бүрэн хариуцна.

7. Угсралтын ажил эхлэхээс өмнө зураг төсөв техникийн нөхцлийн дагуу хийгдсэн эсэхийг хянуулан баталгааг авсан байна.

8. Шалгарсан гүйцэтгэгч нь захиалагч байгуулага болох Мэдээлэл Холбооны Сүлжээ компаний ИТА хамт ажил гүйцэтгэх улаан шугам тавьж акт үйлдэнэ.

9. Ажил гүйцэтгэх үедээ орон нутгийн Мэдээлэл Холбооны Сүлжээ компаний төлөөлөгчийг байлцуулан далд ажлын акт протоколыг тус бүрд нь үйлдэх

Үүнд: 1. Газрын кабелийг дамар тус бүрээр (шуудууны гүн, өргөн, элсэн дэвсгэр, анхааруулах тууз, хөрсний нягтаршуулалт зэргийг) технологийн дагуу хийсэн эсэх.

2. Залгааны муфт, FDF-н залгааны унтралт болон угсралт нь технологийн дагуу хийгдсэн эсэх

3. Кабелийн оруулгын худагт кабелийг стандартын дагуу хийсэн эсэх.

10. Угсралтын ажлыг гүйцэтгэхдээ хөдөлмөрийн аюулгүй байдал болон шилэн кабель суурилуулах стандартыг чанд мөрдөж ажиллах.

11. Угсралтын ажил дууссаны дараа техникийн акт, гүйцэтгэлийн зургийг хүлээлгэн өгөх.

